

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРААС
2020 ОНЫ 09 ДҮГЭЭР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2020 оны 10 дугаар сарын 05

Улаанбаатар хот


Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2020 оны 08 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:

Тайлант хугацаанд Монгол Улсад оршин суух үнэмлэх 2297 шинээр хэвлэн, 298 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 77 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийн, гадаадын дөрвөн иргэнд регистрийн дугаар олголоо. Үйлчилгээний танхимаар 214 иргэн, 117 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэжээ.

Зөвлөгөө, мэдээллийн 1800-1882 дугаарын утсаар 796, 7585-1882 дугаарын утсаар 66, 7013-3459 дугаарын утсаар 13, биечлэн 79, автомат хариулагчаар 286, нийт 1240 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.



2020 оны 08 дугаар сарын тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 60.1 хувиар, виз олголт 91.3 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 77.6 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 74.0 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 68.6 хувиар, түр ирэгчийн бүртгэл 86.6 хувиар, түр ирэгчийн хасалт 91.0 хувиар, визийн сунгалт 51.2 хувиар тус тус буурсан байна.

Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан хөдөлмөр эрхлэгч, хөрөнгө оруулагч гадаадын иргэдийн Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн сунгалтыг цахимаар авч эхэлсэн бөгөөд тайлант хугацаанд “Т” ангиллын таван аж ахуйн нэгж, байгууллагын зургаан гадаадын иргэн, “НГ” ангиллын зургаан аж ахуйн нэгж, байгууллагын есөн гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгалаа. Мөн түр ирэгч гадаадын хоёр иргэний визийн сунгалтын хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэв.

Иргэний харьяалал, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллага, хүүхэд үрчлэлтийн чиглэлээр:


Засгийн газрын 2010 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам”-ын дагуу Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дөрвөн иргэн, харьяалалгүй гурван хүнд хяналт шалгалт хийлээ.

Монгол Улсын харьяатаас гарч Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 10, Бүгд Найрамдах Солонгос Улсын 13, Сингапур Улсын дөрөв, Япон Улсын хоёр, Бүгд Найрамдах Австри Улсын хоёр, Тайвань Улсын нэг, Бүгд Найрамдах Казахстан Улсын харьяат болох хүсэлт гаргасан гурав, нийт 35 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийж байна.

Мөн Бүгд Найрамдах Казахстан Улсын харьяат болох хүсэлт гаргасан найман иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 23, Япон Улсын тав, Бүгд Найрамдах Солонгос Улсын 11, Нидерландын Вант Улсын нэг, Бүгд Найрамдах Австри Улсын харьяат болох хүсэлт гаргасан гурав, нийт 43 иргэний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлэв.

Иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй хоёр хүний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлж ажиллалаа.

Хоёрдмол харьяалал үүсгэсэн 20 иргэнийг шинээр бүртгэж мэдээллийн санд оруулсан ба 2020 оны 08 дугаар сарын байдлаар тус байгууллагын мэдээллийн санд гадаадын 45 улсад хоёрдмол харьяалал үүсгэсэн 3775 иргэн бүртгэлтэй байна.



Тайлант хугацаанд салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан Испанийн Вант Улсад төвтэй нэг төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтийг хүлээн авлаа.

Мөн зөвшөөрлийн хугацаагаа сунгах хүсэлт гаргасан Бүгд Найрамдах Солонгос Улсад төвтэй гурав, Тайвань Улсад төвтэй нэг, Бүгд Найрамдах Чех Улсад төвтэй нэг, Бүгд Найрамдах Франц Улсад төвтэй нэг, нийт зургаан төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газруудад хяналт шалгалтыг хийв. 2020 оны 08 дугаар сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 86 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар байна.

Бүгд Найрамдах Итали Улсын гэр бүлд үрчлүүлсэн гурван хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэв.


1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Оросын Холбооны Улсын нийт долоон иргэн, харьяалалгүй нэг хүнийг байгууллагын даргын зургаан удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

Байгууллагын даргын тушаалаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нэг иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, мөн Бүгд Найрамдах Энэтхэг Улс нэг иргэний хилээр нэвтрэх эрхийг сэргээлээ.

Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-г үндэслэн ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан үндэслэлээр албадан гаргасан Бүгд Найрамдах Солонгос Улс нэр бүхий есөн иргэний Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг байгууллагын даргын тушаалаар сунгав.

Тайлант хугацаанд төлөвлөгөөт нэг, төлөвлөгөөт бус 11 хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 22 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 46 иргэнийг хамруулав. Түүнчлэн 15 гадаадын иргэн, 33 аж ахуйн нэгж, байгууллага /гадаадын 34 иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 18,850,000 /арван найман сая найман зуун тавин мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.



2020 оны 08 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 95.3 хувиар, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 78.3 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 86.0 хувиар, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 66.7 хувиар тус тус буурсан байна.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажил, хүний нөөц, олон нийттэй харилцах чиглэлээр:

Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Гадаадын иргэн, харьяатын газрын удирдлага, албан хаагчдад өгсөн үүрэг, чиглэлийн дагуу 12 үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх 44 арга хэмжээ бүхий нарийвчилсан төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Тус үүрэг, чиглэлийн 2020 оны 08 дугаар сарын биелэлтийг нэгтгэн албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлэн ажиллав.

“Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний төсөлд Гадаадын иргэн, харьяатын газраас тусгах арга хэмжээг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн загварын дагуу бэлтгэн цахим шуудангаар, 2020 оны 07 дугаар сарын байдлаарх үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.

Засгийн газрын 2019 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл олгох тухай” журамд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан 272 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааг сараар тооцон тогтоож, 34 албан хаагчийн төрийн алба хаасан хугацаанд нэмэгдлийг байгууллагын даргын тушаалаар шинэчлэв.

Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргасан хоёр албан хаагчид сануулах, нэг албан хаагчид цалингийн хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан ба албан хаагчдын ажлын цаг ашиглалт, ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлээр найман мэдээ, 13 мэдээлэл, дөрвөн тайлан мэдээг байгууллагын цахим хуудас болон цахим сүлжээгээр олон нийтэд мэдээлэв. Тухайлбал, “Гадаадын иргэн, харьяатын газрын даргаар цагдаагийн хурандаа Н.Ууганбаяр томилогдлоо” мэдээ www.gogo.mn, www.ikon.mn, www.news.mn, www.zindaa.mn, www.24tsag.mn, www.tovch.mn, www.montsame.mn зэрэг 10 цахим хуудас, “ТВ5” телевиз, “NTV” телевиз, “Зууны мэдээ” сонинд, “Гадаадын иргэн, харьяатын газрын Мэдээллийн лавлах төв тогтмол ажиллаж байна” мэдээ www.montsame.mn цахим хуудаст тус тус нийтлэгдэв.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 53 өргөдөл ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 42 өргөдөл шийдвэрлэгдэж, 11 өргөдөл шийдвэрлэлтийн шатандаа байна. Нийт өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэлээ.

2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх явцад тулгарч буй хүндрэл бэрхшээл, боловсронгуй болгоход холбогдох санал, Катар болон Монгол Улсын бүх төрлийн паспорт эзэмшигч иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар санал, Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгах шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал, Эрх зүйн шинэтгэл-2 бодлогын баримт бичигт өгөх саналыг тус тус боловсруулан салбарын яаманд хүргүүлээ.

Тайлант хугацаанд хоёр албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлэн ажиллав.

Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд танилцуулах, авлигаас ангид байхыг уриалах зорилгоор “Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт”, “Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт”, “Хандив авахтай холбогдсон хязгаарлалт” сэдвээр тус тус мэдээлэл бэлтгэн байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр хүргэн ажиллаж байна.

Байгууллагын дарга, дэд дарга тэргүүтэй төлөөлөгчид Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яамны Элчин зөвлөх Ноён Хаяаши Шиничиротой уулзалт хийн хоёр орны иргэдийн харилцан таатай зорчих нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр, Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайд Ноён Цай Вэньруйтэй уулзалт хийн цар тахалтай холбогдуулан хоёр улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр санал солилцож, цаашдын хамтын ажиллагааны талаар хэлэлцэв.

Мөн дарга, дэд дарга тэргүүтэй төлөөлөгчид Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын хөтөлбөрийн ажилтан Р.Оюунбилэгтэй цаашдын хамтын ажиллагаа болон хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн талаар, Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яамны Консул Ноён Кил Кан Мугтай цар тахлын үед Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдэд тулгарч буй виз, оршин суух зөвшөөрөлтэй холбоотой асуудлын хүрээнд мэдээлэл өгч цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Гадаадын иргэний бүртгэлийн программ хангамжийн хөгжүүлэлтийн хүрээнд хамгийн олон гадаадын иргэн бүртгэгдсэн зочид буудлуудыг график хэлбэрээр харуулах, Монгол Улсад ирсэн гадаадын иргэдийг “evisa.mn” системээр нэвтэрч бүртгүүлэх хөгжүүлэлтийг хийлээ.

“CAO” /Иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, төрийн бус байгууллагын бүртгэл/ программ хангамжийн хэрэглэгчийн шаардлагын дагуу Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоох бүртгэлийн хэсгийг шинээр, объектын судалгааны программ хангамжийн хэрэглэгчийн шаардлагын дагуу шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэх, шалгалтад хамрагдсан уригч иргэнийг бүртгэх, шалгалтад хамрагдсан хувь хүнийг бүртгэх хэсгийн хөгжүүлэлтийг тус тус хийж ажиллагаанд оруулав.

2.4. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2020 онд 7,729,8 сая төгрөг батлагдсанаас 08 дугаар сарын байдлаар 5,179.4 сая төгрөгийн санхүүжилт олгогдож 4,160.3 сая төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцууллаа.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 08 дугаар сарын байдлаар 993.8 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 364.4 сая төгрөгийн хүү торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэв.

Төв болон орон нутаг дахь газруудын 07 дугаар сарын төсвийн зарцуулалтын тайланг Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэн баталгаажуулж, 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн хамт байгууллагын цахим хуудаст байршуулсан.

2020 оны батлагдсан төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг албаны хэрэгцээнд шаардлагатай байгаа харьяалах нэгжүүдэд балансаас баланст шилжүүлэх асуудлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, хурлаар гарсан шийдвэрийг Хууль зүй, дотоод хэргийн яам болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт албан бичгээр хүргүүллээ.

2.5. Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн чиглэлээр:

Байгууллагын 2020 оны 07 дугаар сарын үндсэн үйл ажиллагааны мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын Ажлын албанд, Гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын 2020 оны 07 дугаар сарын статистик мэдээг салбарын яаманд тус тус албан бичгээр хүргүүлэв.

2019, 2020 оны байгууллагын даргын албан даалгаврын хэрэгжилт, 2020 оны эхний хагас жилд тус байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга болон шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж байна.

“COVID-19” халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор хилийн боомтоор нэвтрэх зорчигчийн хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбогдуулан олон улсын тээвэр гүйцэтгэж байгаа гадаадын иргэн болон тусгай үүргийн нислэгээр ирсэн 35 улсын 4026, хилээр гарсан 40 улсын 3320 гадаадын иргэний хил нэвтрэлтэд хяналт тавин ажиллалаа.

ДАРГА

Н.УУГАНБАЯР

ТАНИЛЦСАН:
ДЭД ДАРГА

Д.МӨНХБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

Д.ДАВААНЯМ

НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

Д.ГАНТУЛГА